

дамнасан алс холын их замын харилцаа холбоо бий болсон байна. Дэлхийн гурван их шашин, хүн төрөлхтөний гурван их арьстан, олон үндэстэн угсаатан, овог аймгуудын хүмүүс нүүр учирч, харилцаа холбоо, хамтын ажиллагаа тогтоон улмаар ихэд найрамдан ижилсэж ирсэн байдаг. Чухам тэр үед өрнө дорно, өмнө умрыг холбосон торгоны их замын үйл ажиллагаа бүх талаар дээд цэгтээ тултал өрнөн дэлгэрсэн байв.

Энэ бүхний улмаас урьд нь аян дайны хөлд нэрвэгдсэн Ази, Европын олон улс орон шинэ үндсэн дээр сэргэн хөгжиж, дахин урагшлан мандах суурь тавигдсан байдаг. Монголын эзэнт гүрэн нурсны дараа Хятад, Орос, Иран, Дундад Ази болон Дорнод Европын зарим улс орны нэгдмэл байдал батжиж, улс төр, эдийн засаг, соёлын хөгжил түргэссэн нь зөвхөн Монголын ноёрхлыг устгасны үр дүн биш, харин тэрхүү ноёрхлын үед нэгэнт аажим бэлтгэгдэж, нөхцөл бүрдэгдсэний ачаар тийм болсон хэрэг хэмээхэд бүрэн болно.

Тийм учраас Монголын байлдан дагуулын хор хөнөөлийг үгүйсгэлгүй тэмдэглэж ярихдаа ч гэсэн дээр дурдсан утга учир, ач холбогдол бүхий зүйлсийг анхаарч, эрхбиш эхийг эшээж, тугалыг тураахгүй байхыг сургалт хүмүүжил, соёл урлагийн туурвил бүтээлд зохих ёсоор анхаарч ханддаг болох явдал зайлшгүй шаардлагатай чухал зүйл болоод байна.

Чингис хаан, Их Монгол улс, Монголын байлдан дагуулын асуудлыг бодит байдлаар үнэн зөв тавьж, тусган ажиллах нь улс төр, олон улсын харилцаа, үзэл онол, ёс суртахуун, хүмүүжил боловсролын олон талын чухал ач холбогдолтой билээ. Тийм учраас ардчилал, шинэчлэлийн орчин үеийн нөхцөлд тухайн асуудлыг зохих ёсны хэмжээ, түвшинд зөв зүйтэй тавьж уламжлан төлөвгүүлэх явдал эрхэм зорилт болж байгаа юм.

МОНГОЛ ДАХЬ ӨӨРЧЛӨН
БАЙГУУЛАЛТ

**ХАНДИВЛАГЧ ОРНУУД БА
ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХУЧИН ЗҮЙЛ
ТҮҮНИЙ ТӨЛӨВ**

Ч. Ганзориг

Нэг. Эдийн засгийн хамтын ажиллагааны өнөөгийн байдал

Монгол орон сүүлийн хэдэн арван жилийн туршид чиг баримжаагаа болгож ирсэн нийгмийн байгууллын хэв загвараас татгалзаж, ардчилал, чөлөөт эдийн засаг, гадаад харилцааны нээлттэй бодлогын

*Ч. Ганзориг-Үндэсний Хөгжлийн Газрын Эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга

замд эргэлт буцалтгүй орж, эдийн засгаа төвлөрсөн төлөвлөгөөт тогтолцооноос зах зээлийн харилцаанд шилжүүлэх шинэлэг бөгөөд амаргүй зорилтыг хэрэгжүүлж байна. Шилжилтийн үе хялбар биш, гадаад, дотоод олон хүчин зүйлээс шалтгаалсан ихээхэн хүндрэл, бэрхшээлтэй тулгарч байгааг манай өнөөгийн амьдрал тов тодорхой харуулж байна.

Монгол орон хэдэн арван жилийн турш хуучин ЗХУ-аас эдийн засгийн хараат байдалд байлаа. 1980-аад оны сүүл гэхэд гадаад худалдааны 85 гаруй хувь нь ЗХУ-д ногдож байсан бөгөөд улсын төсвийн алдагдлын нэлээд хэсгийг ЗХУ-ын зээл, тусламжаар санхүүжүүлж байна.

Гэтэл ЗХУ задарч, хоёр орны худалдааны тогтсон систем өөрчлөгдөхийн зэрэгцээ эдийн засгийн харилцааны шинэ шаардлагын дагуу дээрх хэлбэрт санхүүжилт 1991 оны 1 дүгээр сарын 1-нээс бүрмөсөн зогсож эхлэнгүүт импорттод шүтсэн орны эдийн засаг яаж амархан тамир алдарч хямралд орсныг тайлбарлах хэрэггүй бизээ.

Ийм үед Монгол Улс эдийн засгийн шинэчлэлийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай тусламж, дэмжлэг авах асуудлыг 1990 оны эцсээс хоёр талын шугамаар болон олон улсын байгууллагуудад хүсэлт болгон тавьсан юм.

Монгол Улсын эдийн засгийг өнөөгийн хямралаас гаргах, цаашдын хөгжлийн үндэс суурийг тавихад гадаад эдийн засгийн хамтын ажиллагаа шийдвэрлэх ач холбогдолтой болж байна.

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих чиглэлд дэлхий нийтийн харилцааны жишгийн дагуу гадаад нээлттэй эдийн засгийн бодлого баримтлан ажилласны дүнд дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудтай харилцан ойлголцож, тэдэнтэй идэвхтэй хамтран ажиллаж эхэллээ.

Өнгөрсөн хугацаанд хандивлагчдаас амалсан тусламжийн 40,7%-ийг буцалтгүй тусламж, 59,3%-ийг зээл эзэлж байгаа бөгөөл 1991-1993 онд ашиглавал зохих нийт зээл, тусламжийн 58%-ийг ашиглаад байна.

	амлалт	гүйцэтгэл	хувь
Санхүүгийн	249,0	171,3	68,8
Төслийн	226,6	56,7	25,0
Техникийн	114,2	74,1	64,9
Барааны	113,8	109,1	95,9
ДҮН	703,6	411,2	58,4

Зээл тусламжийн зориулалт, бүтцийг аваад үзвэл эхний үед, тухайлбал 1991 онд нийт тусламжийн бараг 70 гаруй хувь нь төлбөрийн тэнцлийг хангах санхүүгийн болон барааны тусламж, дөнгөж 10 гаруй хувийг төслийн зориулалттай тусламж эзэлж байсан бол энэ харьцаа өөрчлөгдөж 1993 онд 10 орчим хувийг санхүүгийн болон барааны тусламж, 60 гаруй хувийг төслийн зориулалтаар ашиглахаар төлөвлөж байна. Энэ нь хандивлагчдын тусламжийн дийлэнх хэсгийг яаралтай тусламжид чиглүүлж байсан 1991 оны зөвлөлгөөнөөс бүтцийн хувьд өөрчлөгдөж байгааг харуулж байна.

	1991/1992		1992/1993		1993/1994	
	тоо	бүтэц	тоо	бүтэц	тоо	бүтэц
Санхүүгийн	125,8	49,0	123,2	27,6	19,0	8,2
Төслийн	33,5	13,1	193,1	43,2	154,3	66,3
Техникийн	40,3	15,7	73,9	16,5	54,3	23,3
Барааны	57,0	22,2	56,8	12,7	5,1	2,2
ДҮН	256,6	100,0	447,0	100,0	232,7	100,0

Тайлбар: Донорын уулзалтаас өмнө буюу хойно дараа амласан тусламжийг нэмж тооцов.

Төлбөрийн балансийг дэмжихэд чиглэсэн санхүүгийн тусламж

1992 оны сүүлч хүртэл Монголын Засгийн газрын гол анхаарал макро эдийн засгийн тогтворжуулалтад чиглэж байна. Өөрөөр хэлбэл урт хугацааны зорилтыг шийдвэрлэхээс өмнө богино хугацааны тулгамдсан зорилтыг шийдвэрлэхэд тусламжийн хөрөнгийг чиглүүлж байлаа. Тухайлбал 1991/1992 онд амласан тусламжийн дийлэнх хэсгийг өвлийг даван туулахад нэн шаардлагатай байсан импортын сэлбэг хэрэгсэл, бараа материал худалдан авахад зориулсан байна.

Техникийн туслалцаа

1991 онд ихээхэн хэмжээний техникийн туслалцаа үзүүлэхээр амласан байна. Энэхүү техникийн туслалцааны хүрээнд, хөдөө аж ахуй, түлш, эрчим хүч, уул уурхай, зам тээвэр, холбоо, үйлдвэр, боловсрол, эрүүл мэнд, удирдлага, нийгмийн хөгжил зэрэг хүрээг хамарсан 100 орчим сэдвээр судалгаа эхэлж үндэслэл хийгдэж байна.

Судалгааны явцаас үзэхэд нийт хийгдэж байгаа судалгааны 50 орчим хувь нь дуусч, холбогдох илтгэл дүгнэлт гараад байна. Тухайлбал холбоо, авто зам, боловсрол, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнүүдийг боловсруулж дуусгаад байгаагийн зэрэгцээ Эгийн голын усан цахилгаан станц, Буянт Ухаагийн нисэх онгоцны буудлын өргөтгөл, малын тэжээл, хөдөө аж. ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулж хадгалах, “Эрдэнэт”, “Говь”

комбинатуудыг өргөтгөн шинэчлэх зэрэг төслүүдийн судалгааны ажил дуусч хэрэгжихэд бэлэн болоод байна.

Техникийн туслалцааны нэг хэсгийг оюуны чадавхийг бүрдүүлэх, зах зээлийн нөхцөлд ажиллах боловсон хүчнийг давтан бэлтгэх, сургахад чиглүүлж байна. Энэ хүрээнд нийт 20 гаруй орон, олон ужын байгууллагаас техникийн туслалцаа авч жилдээ дунджаар 400 орчим хүнийг курс, сургалтад хамруулж байна.

Ингэхдээ эхний ээлжинд аль болох олон хүнд зах зээлийн орны хөгжлийн түвшинг нүдээр үзүүлж танилцуулах зорилгоор богино хугацааны сургалтыг зохион байгуулж байсан бол одоо тодорхой нарийн мэргэжлийн чиглэлээр урт хугацаагаар сургаж бэлтгэх чиглэлийг барьж байна.

Хандивлагч орнууд манай Засгийн газрын хүсэлтийн дагуу тодорхой салбарт зөвлөх мэргэжилтэн илгээн тусалж байна. Нийт 56 зөвлөх мэргэжилтэн ирж ажилласных 31-ийг зах зээлийн харилцааны хууль зүйн үндсийг бүрдүүлэх, макро эдийн засгийн, олон улсын валют санхүүгийн, өмч хувьчлалын, менежментийн зэрэг гол чухал асуудлуудаар авч ажиллуулж байна.

Төслийн тусламж

Төслийн зориулалтаар ашиглах тусламжийн хувийн жин жилээс жилд өссөөр байна. Энэ нь нэгд, Засгийн газар урт хугацааны хөгжлийн асуудалд түлхүү анхаарах болсон, Хоёрт, төрөл бүрийн салбарын судалгаа болон төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулагдсан нь төслийг санхүүжүүлэх амлалтыг 1991/1992 оны 13.1 хувиас 1993/1994 онд 70 шахам хувь болох нөхцлийг бүрдүүлсэн.

Өнгөрсөн хандивлагчдын зөвлөлгөөний бэлтгэл ажлыг хангах явцад манай улсын яам, тусгай газраас дунд хугацаанд хэрэгжүүлэхээр 50 орчим төслийг санал болгосон байна. Эдгээр төслүүдийг 1993-1996 оны хооронд хэрэгжүүлнэ гэж үзвэл шаардагдах гадаадын зээл, тусламжийн хэмжээ 2.5 тэрбум доллар болох байжээ. Үүний зэрэгцээ дээрх төслүүдийг хэрэгжүүлэхэд Монголын талын хувь оролцоог наад зах нь төслийн нийт өртгийн 20-30 хувьтай тэнцүү байна гэж үзвэл ойрын 3 жилд 500-760 гаруй сая ам. доллар/200.0-300 тэрбум төгрөг/ тай тэнцэх хэмжээний дотоод эх үүсвэр шаардагдах болно.

Ийм хэмжээний зээл, тусламжийг олон улсын байгууллага, хандивлагч орноос авахаар санал болгох боломжгүй бөгөөд өөрөөр хэлбэл манай эдийн засгийн дотоод чадавхиас олон дахин хэтэрсэн тооцоо гарч байна.

Эдийн засгийн макро түвшинд хийсэн тооцоогоор 1993-1996 онд хөрөнгө оруулалтын зориулалтаар ашиглагдах бүх эх үүсвэр хил бүр 100.0 орчим тэрбум төгрөг /150-200 сая доллар/-өөс илүү гарах боломжгүй байна. Манай Засгийн газраас Олон улсын валютын сантай тохирсон "ESAF" хөтөлбөрт гадаад орнуудаас авч ашиглах дунд болон урт хугацаатай зээлийн нийт хэмжээг хил бүр 100 орчим сая доллар байхаар тодорхойлсон юм. Учир иймээс Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн зорилго, агуулгыг үндэс болгон өөрийн орны эдийн засгийн бодит боломж, чадавхийг нарийвчлан тооцооны үндсэн дээр дунд хугацаанд хэрэгжүүлэх төслүүдийн тэргүүлэх чиглэл, ээлж дарааллыг зөв онож тогтоох нь чухал байна,

Иймд эдийн засгийн хямралаас богино хугацаанд хохирол багатай гарах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хувийн хэвшил бэхжин хөгжихөд үйлдвэрлэлийн дэд бүтцийн хэвийн найдвартай ажиллагаа шийдвэрлэх ач холбогдолтой болохыг харгалзан Засгийн газрын шугамаар авах хөнгөлөлттэй зээлийн хөрөнгийг тэргүүн ээлжинд үйлдвэрлэлийн дэд бүтцийг хөгжүүлэх зорилгод түлхүү ашиглах чиглэл баримталж байна.

Үйлдвэрлэлийн дэд бүтцийг түрүүлэн хөгжүүлж түүний найдвартай ажиллагааг хангах, хүч чадлын ашиглалтыг сайжруулах, ажиллах байгаа нүүрсний уурхай, дулаан цахилгааны станцуудад технологийн шинэчлэлт хийх, шинэ эх үүсвэр буй болгох, төмөр замын тээх, нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх зэрэг төслийг л сонгон авах нь оновчтой гэж үзэж байна.

Эдийн засгийн аюулгүй байдал, бий болсон нөхцөлөөс үүдэн газрын тос хайж олборлох, боловсруулах асуудалд онцгой анхаарах шаардлагатай байна.

Барааны тусламж

1991-1993 онд хандивлагч орнууд 109.3 сая ам. долларын барааны тусламж үзүүлсэн. Зах зээлийн харилцаа зүгширч, худалдаа хэвийн байдалд орохын хэрээр барааны тусламжийн хэмжээ багасаж байна. Тухайлбал 1991 онд нийт тусламжийн 2.2 хувьтай тэнцэх байсан бол 1993 онд 2.2 хувь болж буурсан.

Эцэст нь манай оронд өрнөсөн шинэчлэлтийг гадаад орон, олон улсын байгууллагууд тууштай дэмжиж, хандивлагч орнуудын хүрээ өргөсөөр ирсэн нь зах зээлийн харилцаанд шилжих үеийн хүндрэл, бэрхшээлийн үр дагаврыг саармагжуулахад чухал ач холбогдолтой байсныг зориуд тэмдэглэж байна.

Монгол-Японы харилцаа өнөөдөр XXI зуун руу чиглэсэн урт хугацааны тогтвортой харилцаа болон төлөвшиж байна.

Сүүлийн жилүүдэд АНУ-тай харилцаа идэвхтэй хөгжиж байна.

Өрнөд Европын орнууд, тухайлбал Герман, Франц, Англи, Дани, Голланд, Итали, Австри зэрэг орнууд манай орны өөрчлөлт шинэчлэлтийг талархан эдийн засгийн туслалцаа, дэмжлэг үзүүлж энэ үндсэн дээр харилцаа өргөжиж байна.

Эдгээр орон, олон улсын байгууллагууд Монголыг дэмжин шилжилтийн үе дэх хүндрэл бэрхшээлийг даван туулахад тусламж дэмжлэг үзүүлж байна.

Энэ хугацаанд эдийн засгийн хамтын ажиллагаа нь бүхэлдээ эдийн засгийн тулгамдсан төвөгтэй асуудлыг шийдэх, гадаад таатай нөхцлийг бүрдүүлэхэд чиглэж ирсэн бөгөөд тэр нь ч зохих үр дүнгээ өгч байна. Гэхдээ манай эдийн засгийн гадаад хамтын ажиллагааны хүрээ улс орны эдийн засгийн өнөөгийн байдлаас үүдэн гадаадаас үзүүлж буй тусламжинд голлон тулгуурлаж байна.

Хоёр. Гадаадын зээл, тусламжийн ашиглалт, зохицуулалтын тухай

Хөгжиж буй орнуудын туршлагаас үзэхэд энэхүү тусламжийг илүү оновчтой, үр ашигтай зарцуулсан орон зах зээлийн харилцаанд түргэн шилжиж чадсан жишээ байна. Иймээс гадаад эдийн засгийн хамтын ажиллагааг тодорхой чиг бодлогын хүрээнд товлосон хөтөлбөртэйгээр явуулах, гадаадын зээл, тусламжийг нэгдсэн зохицуулалт, хяналтын дор хуваарилж, үр ашигтэй ашиглах асуудалд анхаарал төвлөрүүлэх шаардлага чухлаар тавигдаж байна.

Японы Засгийн газар, Дэлхийн банкнаас хамтран манай оронд өрнөсөн өөрчлөлт шинэчлэлтийг талархан дэмжиж Монголыг дэмжигчдийн зөвлөлгөөнийг Токио хотноо 3 удаа зохион байгуулаад байна. 1991 оны анхны зөвлөлгөөнөөс нийт 150, 1992 оны зөвлөлгөөнөөс 320 орчим сая ам. долларын тусламж үзүүлэхээр амасан. 1993 оны намар болж өнгөрсөн зөвлөлгөөнөөр Монголд үзүүлэх тусламжийн хэрэгцээг цаашид жил бүр 150-175 сая ам. доллар байхаар тохирсон болно.

Олон улсын валютын сантай тохирсон “Стэнд Бай” хөтөлбөрийг үндсэнд нь амжилттай хэрэгжүүлж дуусган улмаар бүтцийн өөрчлөлт хийхэд голоюн чиглэсэн дунд хугацааны “ESAF” хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү хөтөлбөрийг Олон улсын вашотын сантай богино хугацаанд амжилттай тохиролцон батлуулснаар манай оронд өрнөсөн өөрчлөлт шинэчлэлтийг гадаад

орон, олон улсын байгууллагууд тууштай дэмжин урт хугацааны зээл, тусламж олгох нөхцлийг бүрдүүлж өглөө,

**Гурав. Монгол Улсын гадаад эдийн засгийн
хамтын ажиллагааны хэтийн төлөв**

Монгол Улсын гадаад эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын үндсэн зорилго нь гадаад хүчин зүйлийг оновчтой ашиглах замаар улс орны эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх, зах зээлийн харилцаанд шилжүүлэхэд таатай нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

А. Эдийн засгийн гадаад хамтын ажиллагааны хүрээнд тодорхой улс, олон улсын байгууллагын онцлог, өвөрмөц чадавхи боломж, ашиг сонирхлыг өөрийн улсынхтай зөв хослуулах зарчмыг тууштай баримтлах болно. Үүнд:

- Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай эдийн засгийн бүх талын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхийг зн тэргүүний зорилтын нэг гэж үзнэ.

- Тусгаар тогтносон улсуудын хамтын нөхөрлөлийн орнуудтай эрх тэгш харилцан ашигтай эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжүүлэхийг чухалчилна.

- Ази-Номхон далайн бүсэд эдийн засаг, соёл, боловсрол, шинжлэх ухаан-техник, хүмүүнлигийн салбарт идэвхтэй гадаад бодлого явуулна. Япон улстай ург хугацааны тогтвортой хамтын ажиллагааг төлөвшүүлэхийн зэрэгцээ БНСУ, Австрали, Энэтхэг болон АСЕАН-ын орнуудтай хоёр талын болон олон талын эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны бага хурал зэрэг тус бүс нутгийн олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллах чиг баримтална.

- АНУ, ХБНГУ, Англи, Франц, Итали, Дани, Нидерланд зэрэг Өрнөдийн хөгжингүй улстай тогтоосон эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагааг аль болох бататган өргөжүүлэх бодлого явуулна.

- Дэлхийн хөгжиж байгаа орнуудтай бололцоотой бүхий л хэлбэрээр хамтран ажиллана.

- НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагуудын богино болон дунд хугацааны үйл ажиллагааны программуудыг манай улсын хөгжлийн чиглэлтэй нягт уялдуулна.

- Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагуудтай тогтоосон

хамтын ажиллагааг улам бататгаж, тэдгээртэй тохиролцон арга хэмжээг тууштай хэрэгжүүлнэ.

-Европын холбоотой эдийн засаг, гадаад худалдааны хүрээнд хамтын ажиллагааг өргөтгөх чиг баримтална.

Б. Нээлттэй бодлогынхоо үүднээс дэлхийн улс орон, олон улсын байгууллагатай эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжүүлэхдээ дараах чиглэлийг удирдлага болгоно. Үүнд:

-Улс орны хөгжлийн хэтийн бодлого, зорилготой нягт уялдуулан эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн салбарыг тогтвортой хөгжүүлэхэд гадаадын зээл, тусламжийг дээд зэргээр үр өгөөжтэй ашиглах.

-Гадаад хамтын ажиллагаа хөгжүүлэхэд зайлшгүй шаардагдах урьдчилсан нөхцөл болох эрчим хүч, бүх төрлийн тээвэр, харилцаа холбоо, мэдээллийн сүлжээ зэрэг дэд бүтцийг хөгжүүлэхэд Засгийн газрын шугамаар үзүүлж буй зээл, тусламжийн хөрөнгийг эн тэргүүнд хуваарилан зарцуулах.

-Гадаад орнуудын зүгээс Монголд хөрөнгө оруулах, худалдаа үйлчилгээ явуулах эдийн сонирхлыг бий болгон бататгахыг зорих.

-Экспортын нөөцийг өсгөх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, улмаар гадаад харилцааны тэнцлийг хангахад чиглэсэн аливаа хамтын ажиллагааг дэмжих.

-Үйлдвэр, аж ахуйн газрыг тэргүүний техник, технологиор шинэчлэх, манай эрдэс түүхий эдийг өндөр түвшинд боловсруулан дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн гаргахад чиглэсэн төсөл болон бусад арга хэмжээг гадаад орнуудтай хамтран ажиллахад анхаарах.

-Тус улсын нутаг дэвсгэрт эдийн засгийн чөлөөт бүсүүд байгуулахад чиглэгдсэн үйл ажиллагаа явуулах.

-Олон улсын аялал жуулчлалыг өргөжүүлэн хөгжүүлэх, түүний материаллаг баазыг нь бэхжүүлэхэд анхаарах.

-Улс орны эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үүднээс аль болох олон талын эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхийг онлон анхаарах.